



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 12 дугаар сарын 28-ны өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-4</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>5-7</i>
<hr/>	
<i>1.Байнгын хорооны тогтоолын төсөл /““Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/</i>	<i>5-6</i>
<i>2.Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийг албан тушаалаас нь чөлөөлөх тухай санал</i>	<i>6-7</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны 12 дугаар сарын 28-ны өдөр
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 18 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 55.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 20 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Бат-Эрдэнэ, Д.Өнөрболор, Б.Энхбаяр, Т.Энхтүвшин;
Эмнэлгийн чөлөөтэй: Т.Доржханд, М.Оюунчимэг;
Чөлөөтэй: Б.Жавхлан, Ч.Хүрэлбаатар.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /““Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Цэрэнпунцаг: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10

60.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд, Х.Ганхуяг, О.Цогтгэрэл, Т.Энхтүвшин, Ч.Ундрам нар орж ажиллахаар тогтов.

Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг ““Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн талаар авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх үед Улсын Их Хурлын гишүүдээс

тогтоолын төслийн үзэл баримтлал Үндсэн хуульд заасан иргэний өмчлөх эрхийг хөндөж байгаа эсэх, хувьцаа эзэмшлийн зохицуулалт Компанийн тухай хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтуудад нийцэж буй эсэх талаар эрх зүйн дүгнэлт гаргуулах тухай саналууд гарсан талаар танилцуулав.

Ц.Цэрэнпунцаг: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасныг баримтлан уг тогтоолын төсөлд эрх зүйн дүгнэлт гаргуулья гэсэн томъёоллоор санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 10 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийг албан тушаалаас нь чөлөөлөх тухай санал

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч Г.Дөлгөөн оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын саналыг танилцуулав.

Саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Цэрэнпунцаг: Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч Ганбямбын Дөлгөөнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх нь зүйтэй гэсэн Улсын Их Хурлын даргын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийг албан тушаалаас нь чөлөөлөх саналтай холбогдуулж Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийг үндэслэн боловсруулсан тогтоолын төслийг танилцуулав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрэм Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 10 минут үргэлжилж, 18 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 55.5 хувийн ирцтэйгээр 10 цаг 30 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**

Ц.ЦЭРЭНПУНЦАГ

Тэмдэглэл хөтөлсөн:

**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ**

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2023 оны 12 дугаар сарын 28-ны өдөр,
Пүрэв Төрийн ордон “Их эзэн Чингис
хаан” танхим 10 цаг 20 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Ц.Цэрэнпунцаг: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг эрье ээ.

Ингээд байнгын хорооны эрх ирцийг та бүхэндээ танилцуулъя.

Ж.Бат-Эрдэнэ гишүүн орон нутагт ажиллаж байна, Доржханд гишүүн өвчтэй, Энхбаяр гишүүн гадаадад томилолттой, Энхтүвшин гишүүн орон нутагт ажиллаж байна. Ингээд бусад гишүүд ирж Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж Байнгын хорооны ирц 55.6 хувьтай ирц бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье ээ.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл. Эрдэнэс Тавантолгойн ХК-ийн хувьцааны талаар авах арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий,

2.Монголбанкны тэргүүн дэд ерөнхийлөгчийн албан тушаалаас нь чөлөөлөх тухай гэсэн 2 асуудал хэлэлцэнэ ээ.

Ингээд хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа орё.

Хэлэлцэх асуудал, нэг. Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье ээ.

Ажлын хэсэг байгуулах тухай Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос тогтоох нь:

1.Эрдэнэс Тавантолгой ХК-ийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Б.Баттөмөр, ажлын хэсгийн гишүүд Доржханд, Ганхуяг, Цогтгэрэл, Энхтүвшин, Ундрам Улсын Их Хурлын гишүүд. Ингээд 2 ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын мэргэжлийн албан хаагчдыг ажиллуулахыг ажлын хэсгийн ахлагч Баттөмөрт зөвшөөрсүгэй.

Ингээд ажлын хэсэг байгуулах тухай асуудалтай холбоотой асуулттай гишүүд байна уу? Алга байна.

Асуулт санал бас цуг явсан юм байна шүү асуулт, саналтай гишүүд алга байна.

Ингээд гишүүд асуулт асууж санал хэлж дууслаа.

Санал хураалт явуулж эхэлье ээ.

Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг

баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Гишүүдийн 60 хувиар санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.

Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийн хэлэлцүүлэг дууслаа.

Эрдэнэс Тавантолгой ХК-ийн талаар авах арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх үед гишүүдийн зүгээс энэ тогтоолын төслийн үзэл баримтлал Үндсэн хуульд заасан иргэний өмчлөх эрхийг хөндөж байгаа эсэх, Хувьцаа эзэмшлийн зохицуулалт, компанийн тухай хуулийн холбогдох зүйл хэсэг заалтууд нийцэж буй эсэх талаар эрх зүйн дүгнэлт гаргуулах тухай саналууд хэлсэн.

Иймээс Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасныг баримтлан уг тогтоолын төсөл дээр эрх зүйн дүгнэлт гаргуулъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Гишүүд ээ анхааралтай байгаарай. Санал хураалт.

Гишүүдийн 60 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

Дараагийн асуудалдаа оръё.

10.25 цагт

Дөлгөөнийг оруулаарай.

Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэж эхэлье ээ.

Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч Г.Дөлгөөн албан тушаалаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирүүлсэн байна аа. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.1-д заасны дагуу Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай саналыг танилцуулъя аа.

Монголбанкны Тэргүүн дэд Ерөнхийлөгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 36 дугаар тогтоолоор Ганбямба овогтой Дөлгөөнийг Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчөөр томилсон бөгөөд Г.Дөлгөөн нь Төв банкны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 3-д заасныг үндэслэн 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийн албан тушаалаас чөлөөлөгдөх хүсэлтээ ирүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.15 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы чуулганы хурал хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Ганбямба овогтой Дөлгөөнийг Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай саналыг эрхлэх асуудлыг харьяаллын дагуу Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцүүлэхээр хүргүүлж байна аа.

Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай санал саналыг хэлэлцээж өгөхийг хүсье ээ.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар.

Санал болон хүсэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна.

Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Саналтай холбогдуулж Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийг үндэслэн Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулсан байгаа.

Ингээд тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулъя.

Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

Ганбямбын Дөлгөөнийг өөрийнх нь хүсэлтийг үндэслэн Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2023 оны 12 дугаар сарын хэднээс байна? Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Санал хураалт явуулж эхэлье.

Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай асуудлыг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжье ээ гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

Гишүүдийн 60 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.

Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцээж дууслаа.

Ингээд чуулган дээр санал, дүгнэлтийг Ундрам гишүүн танилцуулна аа. Ингээд гишүүддээ баярлалаа.

Өнөөдрийн хуралдаан үүгээр өндөрлөлөө.

10:30 цагт

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ
П.МЯДАГМАА